

# Living the LOTUS

*Buddhism in Everyday Life*



VOL. 174

Yүсгэн байгуулагчийн сургаал

## Бурханы хутгийг олох зам мөр

Цагаан Лянхуа Судрыг бурханы хутгийг олох сургаал гэж хэлж болно. Тэгвэл яавал Бурханы хутгийг олох вэ? Уран арга 2-р бүлэгт Бурхан багш “Хэрвээр энэхүү Номыг сонссон хүмүүн, цөм хотлоор Бурханы мөр лүгээ төгсөх болой.” хэмээн батлан хэлсэн байдаг. Би үүнийг үргэлж хэлдэг. Үүнийг сонсоод нэг хүн “Зөвхөн сонсох төдийд Бурханы хутгийг олж чадах уу” хэмээн асуусан байдаг.

“Сонсох” гэдэг нь сэтгэлийнхээ угаас “Яг тийм.” хэмээн ухан ойлгохыг хэлнэ. Тэрнээс биш зүгээр нэг сонсох, мэдлэгээ баяжуулах төдийхөн нь хангалтгүй. Ганцхан зүйлийг ч байсан хамаагүй анхааралтай сонсож, түүнийгээ бодитойгоор хэрэгжүүлэх. Ингэснээр ганцхан бодлоор гурван мянган ертөнц өөрчлөгддөг гэсэн жинхэнэ үнэний хуулийг бодитоор мэдэрч чадна.

Хүмүүсийг зовлонгоос ангижруулж аваръя гэсэн нигүүлсэнгүй сэтгэлээр бурханы үйл хийж үзээгүй хүн бол бурханы сургаалын жинхэнэ үнэ цэнийг огтхон ч ойлгохгүй. Нэг ч болов зүйлийг сургаалын дагуу хийж үзэх юм бол ямар ч хүн жинхэнэ баяр хөөрийг амталж чадна. Рисшо Косей Кай байгууллагын 53 жилийн түүх түүнийг тод томруунаар батлан харуулдаг. Тэрхүү бодисадвагийн үйлийг ганц ганцаар хуримтлуулаад байхад л болно. Хүмүүсийн сайн сайхны төлөө хичээнгүйлэн зүтгэх юм бол өөрийгөө барьж байсан хатуу үзэл бодол, биеийн хүлээс тайлагдан, бурханлаг чанар тань гялалзан гарч ирэх болно. Хүмүүсийг бурханы хутаг олох зам мөрд хөтлөх нь өөрөө бурханы хутгийг олох зам мөр юм.

Living the Lotus  
Vol. 174 (2020.03)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Саитоо Коочироо

**Орчуулсан:** Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд,

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## Сэтгэл дүүрэн байх аз жаргал

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Хүсэл, шуналаасаа ангижирахад буян ирдэг

“Хүсэл, шунал ихт хүний сэтгэл хийгээд будрах цас Хунгарлах тусам замаа умартана.”

Цаг улирал урин хаврыг угтах гэж буйн зэрэгцээ исгэрэх хүйтний тухай өгүүлсэн дуу бөгөөд хэтэрхий шуналтай байх юм бол хүний алхах ёстой зам мөрөөс нэг л мэдэхэд хазайсан байдаг гэсэн утгатай.

Энэ сард 82 жилийн ойгоо угтах манай байгууллагыг Нивано Никкёо үүсгэн байгуулагчтай хамтран үндсийг нь тавьсан Наганүма Мёокоо багштан, харин ч “Хүсэл, шуналаасаа ангижирахад буян ирдэг.” хэмээн үргэлж сургадаг байжээ.

Хүсэл шунал гэдэг хүнд байгалиасаа байдаг зүйл учраас амьдралд хэрэгтэй зүйл. Гэхдээ хэтрэх юм бол “Тийм юмтай болмоор байна.”, “Үүнийг ч бас өөрийнхөөрөө байлгамаар байна.” гэж зөвхөн өөрийн эрх ашиг, хүсэл шуналдаа баригдаж, бусдад санаа тавихаа хоёрдугаард тавьдаг. Толгойд нь “Би” буюу “Миний асуудал” гэдэг зүйл л эргэлддэг болохоор тэр.

Харин аливаад дундуур дүүрнээр сэтгэл ханаж чаддаг нэгэн бол бусдыг бодох уужуу сэтгэлтэй байдаг. Жишээ нь дуртай юмаа авсан ч гэсэн “Ганцаараа идэх хайран юм. Бусад хүмүүст ч бас өгье.” гэсэн сэтгэл аяндаа л ундрэн гарч ирдэг. Ер нь дундуур дүүрэнгийн ойлголтыг авсан хүн хэрэгцээ шаардлагаас хэтэрсэн зүйлийг хүсдэггүй гэж хэлж болно.

Тийм хүнлэг бодол, бусдыг гэсэн сэтгэл нь үйл хөдлөлөөр илрэхийг “Хүсэл, шуналаасаа ангижирахад буян ирдэг.” хэмээн сургасан гэж бодож байна. Өөрөөр хэлбэл хүнд төрөлхийн байдаг нигүүлсэнгүй сайхан сэтгэл, ач буян нь оргилон гарч ирдэг гэсэн үг.



## Зөвхөн талархал

Цагаан Лянхуа Судрын “Эрдэнэсийн суварга үзүүлсэнийг өгүүлэх 11-р бүлэг”-т энэ судрын сургаалыг сурч, хэрэгжүүлэгч хүнийг жинхэнэ бурханы зам мөрд зүтгэгч гэх бөгөөд “Үүнийг болбоос шагшаабадыг сахигч, Дүтагаар явагч хүмүүн хэмээмүй.” гэсэн байдаг.

Толь бичигт өгүүлсэнээр “Дүта” гэдэг нь “Нисванисыг хөөн зайлуулах” гэсэн утгатай бөгөөд үүний төлөө “Дүтагийн үйл” буюу өдөрт нэг хооллох эсвэл хуучирсан даавуугаар хийсэн хувцас өмсөх гэх мэт үйлд хичээнгүйлэн шамддаг ажээ.

Дүтагийн үйл гэхээр “Тэргүүн зэргийн дүтагийн үйл хэрэгжүүлэгч” гэгддэг байсан Бурхан багшийн шавь Махакаашяпа санаанд орно. Махакаашяпа “Хувцас, хоол хийгээд гэр орны талаар огтхон ч гомдол хэлэлгүй, сэтгэл хангалуун амьдардаг байсан.” гэдэг.

Энэ нь орчин үеийн хүмүүс бидэнд биелүүлэхэд бэрх санагдаж магадгүй ч тийм хэцүү зүйл биш. “Аливаа зүйлд сэтгэл хангалуун бус байгаагаа ил гаргалгүй, сэтгэл хангалуун байх.” гэдэг нь оногдсон зүйлдээ талархаж, санааныхаа зоргоор зөв, буруу гэж гомдоллохгүй байхыг хэлнэ. Мөн зарим ном сударт маш энгийнээр “Багыг хүсч, ханахаа мэдэх” хэмээн тайлбарласан байдаг. Тэгэхээр хүсэл, шуналаа хязгаарлаж, байгаа юмандаа сэтгэл хангалуун амьдрах, өөрт оногдсон зүйлийг аль болох байгаагаар нь хүлээн авч, талархах гэсэн бидний өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлдэг зүйлтэй адилхан байгаа юм.

Мөн өөрийн гадна дүр төрх ямар ч байсан хамаагүй өөлж гоочлох нь “Амь насаа үгүйсгэн хорлохтой адил буюу амьтны амь үл хөнөөх гэсэн сахил (шагшаабад)-ыг зөрчиж байна гэсэн үг” гэж сурч байсан юм байна.

Тэр утгаараа өмнө өгүүлсэн судрын “шагшаабадыг сахих” гэдэг нь ямар ч зүйлийг муучилж гоочлохгүй амьдрах гэсэн утгыг илэрхийлнэ. Гэхдээ бид Цагаан Лянхуа Судрын сургаалыг сурснаар талархах сэтгэл гэдэг зүйлийг мэдэж авдаг учраас л ингэж амьдарч чаддаг билээ. Тэгвэл энэ судраар дамжуулж бурханы сургаалыг сурч буй бидний гарт “сэтгэл дүүрэн байх аз жаргал” үргэлж байдаг гэж хэлж болох болов уу.

Гэхдээ үүнийг хичнээн мэдэж байсан ч гэсэн аливааг талархан хүлээж авч чадахгүй үе бий. Тийм үед алга хавсран мөргөх зэрэг “хэлбэр”-ээс эхлэсэн ч болно. Жишээлбэл хооллох үедээ “Сайхан хооллоорой.” гэж хэлээд алга хавсран мөргөх нь хоол хүнсний амь нас, идэх хоолтой байгаадаа, цаашлаад амьдарч байгаадаа талархах сэтгэлийг өсгөн хүмүүжүүлдэг.

Өөрт оногдсон бүх зүйлд алга хавсран мөргөж амьдрах амьдралд талархал, баяр хөөр, жинхэнэ сэтгэл ханамж, аз жаргал оршдог.

«Косей» 2020 оны 3 дугаар сарын дугаар





# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## «Оройн Дээд Цагаан Лянхуа Судар» Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх 13 дугаар бүлэг (2)

### Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх бүлгийн 20 бадаг

Уг бүлгийн хамгийн гол хэсэг нь төгсгөлийн “Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх бүлгийн хорин бадаг” (Эртний ханзаар бичсэн судар нь 4 мөрийг нэг бадаг болгон нийт 20 бадгаар бичигдсэн байдаг тул ингэж нэрлэсэн) юм. Ничирэн хутагт энэ бадагт өгүүлсэн зүйлс бүгд өөрт нь тохиолдсон явдлаас үүдэн “Бид л ирээдүйн ертөнцөд Цагаан Лянхуа Судрын сургаалыг түгээн дэлгэрүүлэх үүрэгтэй төрсөн.” хэмээн ухаарсан гэсэн алдартай яриа байдаг. Тэрхүү хорин бадгийн гол утга санаа доорхийн адил болно.

“Бид Бурханыг зүрх сэтгэлээсээ хүндэтгэн дээдэлдэг тул Бурханы хамгийн дээд сургаал болох энэхүү судрыг Бурхантай адил хүндэтгэн үзнэ. Тиймээс энэхүү Цагаан Лянхуа Судрыг сахин хамгаалж, түгээн дэлгэрүүлэхийн тулд гаднаас учирч болох бүхий л саад тотгор хийгээд зовлон бэрхшээлийг тууштайгаар хүлцэн тэвчинэ. Бид амь нас зэргийг хайран гэж бодохгүй (Өөрийн амь биеийг үл хайрлана). Гагцхүү энэхүү оройн дээд сургаалтай учирч чадахгүй нэгэн байх аваас тэр л юу юунаас илүү харамсалтай (Дээргүй зам, мөрийг эрхэмлэнэ) юм.

Нийгмийн энгийн ард иргэдийн сургаалыг ойлгоогүйгээс үүдэн бий болох басамжлал, бусад шашны урсгалын лам хуврагын дайсагналаас бий болох хор хөнөөл, дарамт, эрх мэдлийн хүчээр энэхүү сургаалыг зориудаар үл тоомсорлон, нураан унагахыг хүсэгчдийн хүчнээс ч, бүгдээс нь айж ичилгүйгээр хаана ч байсан сургаалыг түгээн дэлгэрүүлэх болно.

Бид яахын аргагүй Ялж төгс нөгчсөний элч билээ. Бүхий л хүч чадлаа зориулан, үнэн зөвөөр сургаалыг түгээн дэлгэрүүлэхээ амлан тангараглаж байна. Бурхан багш та санаа зовох зүйлгүй, сэтгэл амгалан байгтун.”

### Гурван төрлийн хүчит дайсан

Энэ бүлэгт Цагаан Лянхуа Судрын гурван төрлийн хүчит дайсны тухай өгүүлдэг. Өнөө цагт шашин шүтэх эрх чөлөөтэй болсон тул хоёр мянган жилийн өмнөх Энэтхэг улс дахь Цагаан Лянхуа Сударт итгэгчдийн үзэж туулсан шиг эсвэл долоон зуун жилийн өмнө Ничирэн хутагтад тохиолдсон шиг саад тотгор тохиолдохгүй ч, орчин үеийн хэв шинжтэй, туйлын төстэй саад бэрхшээлүүд яалт ч үгүй байна.

Нэгдүгээрхийг “Эгэл их зант хүмүүс” гэх ба Цагаан Лянхуа Судрыг уншиж ч байгаагүй, утгыг нь ч бараг мэдэхгүй атал хэт өөрсдийгөө дөвийлгөсөн сургаал хэмээн буруушааж, түүнд итгэгчдийг басамжлах эгэл жирийн хүмүүсийг хэлнэ. Үүнд өнгөрсөн үеийн Цагаан Лянхуа Сударт итгэгчдэд ч гэсэн хагас буруу байгаа тул бид түүнээс суралцаж, зөвхөн Цагаан Лянхуа Судрыг дөвийлгөн шүтэн бишрэх, улс төрийн зорилгоор ашиглах, хэт ашиг хонжооны төлөө





номлох зэргээс татгалзаж, яг л түүний гол үзэл санааг баримтлан, тайван дөлгөөн хийгээд жинхэнэ хүчирхэг сүсэгтэний хувиар биеэ авч явж, сургаалыг түгээн дэлгэрүүлбэл зохилтой.

Хоёрдугаархыг “Номын их зант хүмүүс” гэх ба бусад шашин хийгээд шашны урсгалын лам хувраг хүмүүс шалтгаангүйгээр дайсагнаж, Цагаан Лянхуа Судрын жинхэнэ утга санааг үл ойшоохыг хэлнэ. Шашин, ялангуяа бурханы шашны нэгэн том үзэл санаа бол хүлээцтэй чанар байдаг. Алдаа хийсэн нэгнийг өршөөж, бүх хүний төлөө байх нь шашин юм.

Тиймээс сургаал номлол, ёс дэгийн өнгөц ялгаанаас болж, сэтгэл хөдлөлөөр бусад шашин, шашны урсгалыг дайсагнан үзэхийг шашин гэхгүй.

Хэрэв Цагаан Лянхуа судрыг хэрэгжүүлэгч бид тийм хүмүүстэй тулгарах шаардлагатай болох юм бол, бид өөрсдөө хүлээцтэй тэвчээртэй чанарыг баримтлах хэрэгтэй. Ямар ч үед тэвчээртэй байж, тэдгээр хүмүүст шашны гол санааг ухааруулахын төлөө цөхрөлгүй хичээн зүтгэх ёстой.

Гуравдугаархыг “Гэгээнтний дүр исгэгч их зант хүмүүс” гэх ба шашин, шинжлэх ухааны ертөнцөд өндөр байр суурьтай, олны хүндэтгэлийг хүлээсэн хүн эрх мэдэлдээ автаж, эсвэл байр сууриа хамгаалах үүднээс зөв сургаалыг үгүйсгэхийг хэлнэ. Үнэхээр агуу хүн бол “Энэ л жинхэнэ үнэний сургаал.” хэмээн олж мэдсэн бол түүнийг эрс шийдэмгийгээр дэмжих ёстой. Харин ахар бодолтой нэгэн бол шинээр гарч ирсэн сургаалыг үл тоомсорлох, илүү мундаг сургаалыг хүлээн зөвшөөрч чадахгүй байх нь элбэг. Тийм болохоор “Тэр бол агуу гэгээнтэн хүн учир худал хэлэх учиргүй.” гэсэн олон нийтийн итгэл, хүндлэлийг санаатайгаар ашиглан зөв сургаалын эсрэг турхирдаг. Ийм хүний нөлөө асар өргөн цар хүрээг хамардаг учраас энэхүү “Гэгээнтний дүр исгэгч их зант хүмүүс” -ийг гурван дайсан дотроос хамгийн хор хөнөөл ихтэй нь гэж үздэг.

Бид бүхэн тийм дайсантай халз тулалдах ямар ч шаардлагагүй ба өөрсдийн итгэдэг жинхэнэ үнэний сургаалыг эцсээ хүртэл зөв замаар, өргөнөөр түгээн дэлгэрүүлж явахад л болно. Яагаад гэвэл жинхэнэ үнэний сургаал устаж үгүй болно гэж үгүй. Нөгөөтэйгүүр хэрэв бид тийм эрх мэдэлтэй хүн болох юм бол яасан ч

тийм их зан гаргаж болохгүй бөгөөд маш сэргэг ухаан, уян хатнаар залуу хүний санал, үзэл бодлыг хүлээж авч, тусган хэрэгжүүлдэг байхыг хичээх хэрэгтэй.

### Амь биеэ үл хайрлан сургаалыг түгээх

Энэхүү хорин бадагт гардаг “Өөрийн амь насыг үл хайрлан Дээр үгүй зам мөрийг эрхэмлэнэ.” гэсэн гайхамшигт мөрөөс “Амь биеэ үл хайрлан сургаалыг түгээнэ.” гэсэн Цагаан Лянхуа Сударт итгэгчдийн уриа бий болсон.

Мэдээж одоогийн хүмүүсийн хувьд “Амь биеэ үл хайрлан сургаалыг түгээх” гэдэг нь амь насаа хайхрахгүй байх гэсэн утгатай бус хувийнхаа эрх ашгийг бодохгүй байх гэсэн утгатай болно. Өөрөөр хэлбэл “Цаг хугацаа, хичээл зүтгэл огтхон ч хайран биш. Мөн хүмүүс ямар нүдээр харж, юу гэж хэлэх бол гэдгээс өчүүхэн төдий ч айж эмээх хэрэггүй.” гэсэн үг юм.

Яагаад гэвэл түүнээс илүү жинхэнэ үнэн (Цагаан Лянхуа Судрын сургаал) эрхэм учраас тэр билээ. Энэхүү оройн дээд сургаалтай учраагүй хүн нэг ч болов байна гэдэг л хайран. Үүнийг чин сэтгэлээсээ мэдэрсэн хүнийг жинхэнэ Цагаан Лянхуа Сударт итгэгч гэж хэлж болно.



## Сэтгэл дүүрэн байх аз жаргал

РКК байгууллагын үүсгэн байгуулагдсан сартай золголоо. 82 жилийн өмнө Үүсгэн байгуулагч, Хамтран үндэслэгч Мёокоо нар тус байгууллагыг байгуулаагүй байсан бол би өнөөдөр хаана, юу хийж явах байсан бол? Ингээд бодохоор үнэхээр талархах сэтгэл төрнө.

Ерөнхийлөгч энэ сарын сургаалдаа “Шунал хүслээс ангижирснаар буян ирдэг” гэсэн Мёокоо багштаны үгийг иш татаж, одоо байгаа бүх зүйлдээ талархсанаар шунал хүслээс ангижирч, сэтгэл ханамжийг мэдэрч амьдарч чадна хэмээн сургасан.

Үүсгэн байгуулагч “Аль болох олон хүнд Лянхуа сударт айлдсан амьдрах ухааныг ойлгуулж, жинхэнэ аз жаргалыг олж аваасай.” гэсэн зорилгоор энэ байгууллагыг байгуулсан.


Бид үүнд талархаж, энэ сар гишүүн элсүүлэх, сургаал түгээх үйлсэд улам их хичээх хэрэгтэй болов уу гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Саитоо Коичи





# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
 Email: [info@rkhawaii.org](mailto:info@rkhawaii.org) URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
 POBox 33636, CA 90033, USA  
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
 Email: [rk-la@sbcglobal.net](mailto:rk-la@sbcglobal.net) URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
 POBox 778, Pacifica, CA 94044, USA  
 TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437  
 Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org) URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
 TEL: 1-212-867-5677 Email: [rkny39@gmail.com](mailto:rkny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
 TEL: 1-773-842-5654  
 Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
 Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA  
 TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
 URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437  
 Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org) URL: <http://www.rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA  
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745  
 Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261  
 Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
 URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
 Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

### Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

### 在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

### 在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

### 社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

### 台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

### Risho Kosei-kai South Asia Division

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

### Risho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

### Risho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

### Risho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,  
Bihar, India

### Risho Kosei-kai of Patna Dharma Center

### Risho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

### Risho Kosei-kai of Singapore

### Risho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

### RKISA Risho Kosei-kai International of South Asia

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

### Risho Kosei-kai of Bangkok

Thai Risho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairisho@gmail.com

### Risho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

### Risho Kosei-kai of Polonnaruwa

### Risho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL/FAX: 880-31-626575

### Risho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

### Risho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

### Risho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

### Risho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

### Risho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

### Risho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

### Risho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

### Risho Kosei-kai Friends in Shanghai

### Risho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

### Risho Kosei-kai of Erdenet

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum,  
Orkhon province, Mongolia

### Risho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia

TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

### Risho Kosei-kai of the UK

### Risho Kosei-kai of Paris

### Risho Kosei-kai of Venezia

### Risho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>